

## 2019 ОНД ИМПОРТЛОХ СТРАТЕГИЙН ХҮНСНИЙ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН УРИЛГА

Шалгаруулалтын дугаар: СХЭИЗОСШ-20190124

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нь Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.8 дахь заалт, Засгийн газрын 2013 оны 77 дугаар тогтоолоор баталсан “Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох түр журам”-д заасны дагуу 2019 онд импортлох стратегийн хүнсний нэр төрөл, тоо, хэмжээнд багтаан зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг зарлаж байна. Үүнд:

Үрийн улаанбуудай - 10000 тн /арван мянга/  
Улаанбуудай-хөх тариан холимог гурил 1000 /нэг мянга/  
Улаанбуудайн гурил - 11000 тн /арван нэгэн мянга/  
Үхрийн мах - 500 тн /таван зуу/  
Хуурай сүү - 6000 тн /зургаан мянга/  
Шингэн сүү – 720 тн /долоон зуун хорь/

Оролцогч нь дор дурдсан баримт бичгийг бүрдүүлж, битүүмжлэн, 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 16 цаг 00 минутаас өмнө Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны 504 тоот өрөөнд бүртгүүлж, хүлээлгэн өгнө. Үүнд:

1. Импортлох хүнсний нэр төрөл, тоо хэмжээг заасан албан бичиг;
2. Хуулийн этгээдийн нэр, байршил, хаяг, утас, факсын дугаар, цахим хаяг;
3. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар, эрхэлж байгаа хүнсний чиглэлийн үйл ажиллагаан төрөл, хэлбэр;
4. Татварын өргүй болохыг тодорхойлсон харъяалах татварын албаны тодорхойлолт;
5. Аудитаар баталгаажсан 2018 оны санхүүгийн тайлан;
6. Стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангасан зориулалтын агуулах, тээврийн хэрэгсэлтэй эсэхийг нотлох баримт бичиг, эсхүл энэ шаардлагыг хангасан агуулахыг түрээслэх тухай хуулийн этгээдтэй байгуулсан гэрээний нотариатаар баталгаажуулсан хувь;
7. Экспортлогч улсын импортлох бүтээгдэхүүнд олгосон гарал үүслийн болон чанарын гэрчилгээ, шинжилгээний дүн;
8. Экспортлогч улсын үйлдвэр эсхүл түүний албан ёсны гэрээт борлуулагчтай байгуулсан худалдааны гэрээ;
9. Хуулийн этгээдийг төлөөлөн сонгон шалгаруулалтад оролцох этгээдийн итгэмжлэл бүхий албан бичиг;
10. 2017, 2018 онд стратегийн хүнс импортлох зөвшөөрөл авсан аж ахуйн нэгж нь тухайн бүтээгдэхүүнийг 70 хувиас бага хэмжээтэйгээр импортлосон бол хуулийн этгээдийн материалыг хүлээн авахгүй болно.

Сонгон шалгаруулалтад оролцогчийн материалыг хүлээн авах эцсийн хугацаа: 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 16 цаг 00 минут /Хугацаа хоцорсон материалыг хүлээн авахгүй/

Сонгон шалгаруулалтыг нээх хугацаа: 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 17 цаг 00 минут

**ХАЯГ:**

**Монгол Улс, Улаанбаатар-13381, Энхтайваны өргөн чөлөө 16а,  
Засгийн газрын 9 дүгээр байр, Б корпус, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн  
яамны  
5 давхарт, 504 тоот өрөө, Утас: 261962**